



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: [info@cabinet.gov.mn](mailto:info@cabinet.gov.mn),  
Цахим хуудас: [www.mongolia.gov.mn](http://www.mongolia.gov.mn)

дод. 3. 06. 28 № 35-1/105  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг  
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд  
өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хавсралт хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000234002898



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: [info@cabinet.gov.mn](mailto:info@cabinet.gov.mn),

Цахим хуудас: [www.cabinet.gov.mn](http://www.cabinet.gov.mn)

2023. 06. 27 № ХХ/1545  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг  
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр  
шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 5 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 25 дугаар тэмдэглэлд:

“VII.ХЭЛЭЛЦСЭН нь: Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР





**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.06.22 № 7/3508.

танай \_\_\_\_\_-ны № 79/2794-Т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
С.ЧИНЗОРИГ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151603152

А5-Файл.2023



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.06.20 № 01/4570

танай \_\_\_\_\_-ны № 10/2795-т

### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ ТАНАА

Танаас ирүүлсэн Дархлаажуулалтын тухай  
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг  
Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар  
зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их  
Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001385



БАТЛАВ.  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

С.ЧИНЗОРИГ

БАТЛАВ.  
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

## ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

#### 1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй” гэж, тус зүйлийн 6 дахь хэсэгт “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэж тус тус заасан.

Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын иргэн, тус улсад байнга буюу түр оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг дархлаажуулалтад хамруулна” гэж, тус зүйлийн 35.7 дахь хэсэгт “Дархлаажуулалтыг зохион байгуулах асуудлыг хуулиар зохицуулна” гэж тус тус заасан.

Дархлаажуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Заавал хийх дархлаажуулалтад хамрагдах сэргийлэх тарилгын нэр төрөлд хийх өөрчлөлтийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно” гэж, 1990 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн конвенцийн 1 дүгээр хэсгийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана”, тус конвенцийн 24 дүгээр зүйлийн 2В хэсэгт “Нэн тэргүүнд анхан шатны эмнэлэг-ариун цэврийн тусламжийг өргөжүүлэхэд анхаарлаа хандуулан бүх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламжийг үзүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-дахь заалтын 8-д “Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын өвчлөл, сүрээгийн тохиолдлыг бууруулсан байна.” гэж, мөн заалтын 9-т “Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин буурсан байна” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.5.2-т “Монгол Улсын хэмжээнд мөрдөх



заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотыг шинэчлэн батлуулна” гэж тус тус заасан байна.

## **1.2. Практик шаардлага:**

### **А вируст гепатитын халдварын эсрэг вакциныг нэвтрүүлэх практик шаардлага**

2011 оноос өмнө ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн дунд А вируст гепатитын халдварын дэгдэлт бүртгэгдэж, жил бүр 9000 гаруй хүүхэд шинээр өвчилж, өвчлөгсдийн 70 гаруй хувийг 9 хүртэлх насныхан эзэлж, үүнээс 2-4 насны хүүхдийн өвчлөл (10,000 хүн амд 2 настайд 187, 3 настай 185, 4 настайд 169) зонхилж байсан. 2005-2011 онд тархвар судлалын болон сайн дунд үндсэн дээр А вируст гепатитын эсрэг вакцинд хамрагдсан 49,303 хүүхдийн дунд өвчлөл бүртгэгдээгүй байгаа нь энэ вакциныг товлотод оруулах шаардлагатайг харуулж байна.

Эрүүл мэндийн сайдын 2010 оны 417 дугаар тушаалаар А вируст гепатитын халдварын эсрэг вакциныг 2011 оноос эхлэн улсын хэмжээнд тархвар судлалын заалтаар үе шаттай нэвтрүүлж эхэлснээс хойш 1 нас 2 сартай болон 2 настай хүүхдүүдийг одоо хүртэл дархлаажуулж байна. Вакцин нэвтрүүлж эхэлснээр шинэ тохиолдлын тоо 21.5 дахин буурч, 2021 оны байдлаар улсын хэмжээнд 18 тохиолдол буюу 10 000 хүн ам тутамд 0.1 тохиолдол бүртгэгдсэн нь 2011 онтой харьцуулахад өвчлөл 99 дахин буурсан үзүүлэлт юм. 2021 оны байдлаар А вируст гепатитын эсрэг дархлаажуулалтын хамралт 93.5% байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр 2022 оны байдлаар 46 улс А вируст гепатитын вакциныг дархлаажуулалтын үндэсний товлотод нэвтрүүлсэн байна.

Америкийн Нэгдсэн Улсад хийсэн судалгаагаар А вируст гепатитын халдварын эсрэг вакцинжуулалтад бүх нийтийг хамруулахад жил бүр 94,957 халдвар, 46,179 амбулаторийн үзлэг, 1286 эмнэлэгт хэвтэлт, 15 нас баралтаас сэргийлж 21,223 америк долларыг хэмнэсэн бол Бразил, Аргентин Улсад эдийн засгийн үр ашигтай гэсэн ижил төстэй үр дүн гарсан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн судалгаагаар А вируст гепатитын халдварын эсрэг вакцинжуулалтад 457,251 хүнийг хамруулахад дархлаа тогтоц 95 хувь, Бразил, Аргентин Улсад хийсэн судалгаагаар 2-16 насны 994 хүүхдийг вакцинжуулалтад хамруулахад 100 хувийн үр дүнтэй байгааг тус тус нотолсон байна.

Нэг хүүхэд А вируст гепатитаар өвчлөхөд оношилгоо, эмчилгээ, асаргааны зардалд дунджаар 2 сая төгрөг зарцуулдаг бол А вируст гепатитын халдварын эсрэг вакцинд 25 мянган төгрөгийн зардал ногдож байна.

### **Пневмококкийн эсрэг вакциныг нэвтрүүлэх практик шаардлага**

Дэлхийн 195 улс оронд 1990-2016 он хүртэлх хугацаанд оношлогдсон уушгины үрэвслийн тоон мэдээг судалсан судалгаанаас харахад амьсгалын доод замын үрэвсэл хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж, бүртгэгдсэн амьсгалын доод замын халдварын шалтгаант нас баралтын 61.4 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт эзэлж байна.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр 5 хүртэлх насны хүүхдийн 14 хувь нь уушгины хатгалгаа өвчнөөр нас барж, 39 секунд тутам уушгины үрэвслийн улмаас дэлхийд 1 хүүхэд эндэж байна. Хамгийн гол нь уг өвчин урьдчилан сэргийлэх боломжтой халдварт өвчин юм.

Пневмококкийн эсрэг вакциныг дархлаажуулалтын үндэсний товллод Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гишүүн 194 орноос 148 улс орон нэвтрүүлсэн байна.

Монгол Улсад хүн амын дундах өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болох амьсгалын тогтолцооны өвчлөлийн дотор уушгины хатгалгаа өвчин 51.2 хувийг эзэлж, пневмококкийн бактериар үүсгэгдсэн уушгины хатгалгаа өвчин 2 хүртэлх насны хүүхдийн дундах өвчлөл, нас баралтын гол шалтгаан болдог. Пневмококкийн эсрэг вакциныг 2016 оноос эхлэн нийслэлийн дүүргүүдэд, 2017 оноос өвчлөл, эндэгдэл ихтэй зарим аймаг, 2019 оноос улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн. Пневмококкийн эсрэг 13 цэнт вакцины үр дүнг судалсан судалгаагаар пневмококкоор үүсгэгдсэн уушгины хатгалгаа 26 хувь, хүнд хэлбэрийн хатгалгаа 42 хувь, маш хүнд хэлбэрийн уушгины хатгалгаа 46 хувиар тус тус буурсан үр дүнтэй гарсан байна.

Пневмококкийн эсрэг вакцин нэвтрүүлэхээс өмнө нийслэлийн сонгогдсон 5 эмнэлэгт суурилсан харуулдан тандалтын дүн мэдээгээр нийт хэвтэн эмчлүүлсэн 5 хүртэлх насны хүүхдийн 25.4 хувь нь уушгины хатгалгаа оноштой байжээ. Иймд уушгины хатгалгаа өвчин үүсгэгчийн нэг пневмококкийн эсрэг вакциныг дархлаажуулалтын үндэсний товллод нэвтрүүлэх нь Монгол Улсын нийгмийн эрүүл мэндийн салбарт тулгамдаад байгаа нэг чухал асуудлын нэг болно.

Пневмококкоор үүсгэгдсэн уушгины хатгалгаа өвчин хүүхдэд ихэвчлэн хүнд, маш хүнд явцтай байдаг ба эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэхэд 2-4 сая төгрөгийн зардал гардаг бол пневмококкийн эсрэг вакцины нэг бүрийн үнэ нь 15 мянган төгрөг байна. Пневмококкийн халдвараар хүүхэд өвчлөхгүй, өвчилсөн тохиолдолд хүндрэхгүй байх нь нэн чухал бөгөөд вакцинжуулалт нь хүүхэд хоёрдогч халдвараар хүндрэхгүй байх, архаг үлдэцгүй эдгэрэх, антибиотикт тэсвэржилт үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой.

#### **Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэх практик шаардлага**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Хавдрын судалгааны төвийн 2021 оны мэдээллээр Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдрын өвчлөл, эндэгдэл бүс нутгийн улс орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна.

Тухайлбал Зүүн Өмнөд Азийн орнуудад умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин дундажаар 100 000 хүн амд 10.8, нас баралтын түвшин 4.9 тохиолдол байгаа бол манай улсад 100 000 хүн амд 19.7, нас баралт 11.6 тохиолдол байгаа нь Номхон далайн баруун бүсэд өвчний дарамт хамгийн өндөр үзүүлэлт юм. 2016-2020 оны үзүүлэлтээр Монгол Улсад умайн хүзүүний хорт хавдар эмэгтэйчүүдэд зонхилон тохиолдох хавдрын 2 дугаарт, нийт хорт хавдрын шинэ өвчлөлийн 4 дүгээрт, хавдарын шалтгаант нас баралтын 5 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Хүний папиллома вирус (ХПВ)-ийн эсрэг вакцины нөлөөлөл ба зардал-үр дүнгийн шинжилгээг дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр Олон улсын PATH байгууллага, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв хамтран 2018 онд зохион байгуулсан. Вакцины зардлын-үр дүн, нөлөөллийг олон улсад тооцдог UNIVAC



болон TRIVAC—н загварчлалын дагуу зардал-үр ашгийг 3 хувилбараар тооцон үр дүнг үнэлэхэд вакциныг нэвтрүүлэх нь үр ашигтай бөгөөд товллын вакцинд нь эдийн засгийн үр дүнтэй гэсэн дүгнэлт гарсан байна.

2019 онд Ланцет олон улсын сэтгүүлд нийтлэгдсэн “Хүний папиллома вирусийн эсрэг вакцинжуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа хүн амд хийсэн дархлал тогтоцыг үнэлэх нь” гэх судалгаанд Америкийн Нэгдсэн Улс, Австрали, Шотланд зэрэг хүний папиллома вирусийн вакцинжуулалтын хөтөлбөртэй 14 гаруй улс орны судалгааны үр дүнг илтгэсэн байна. Уг тойм судалгаагаар хүний папиллома вирусийн эсрэг вакцин нь умайн хүзүүний хорт хавдраас үр дүнтэй сэргийлж байгаа нь нотлогджээ. Тухайлбал Швед, Дани улсад өсвөр насандаа вакцин хийлгэсэн эмэгтэйчүүд насанд хүрсэн хойноо умайн хүзүүний хорт хавдраар өвчлөх эрсдэл бага байгаа нь судалгаагаар тогтоогджээ.

Ланцет олон улсын сэтгүүлд нийтлэгдсэн тойм өгүүллэгт хүний папиллома вирусийн вакцинтай холбоотой нийт 1702 судалгааны өгүүллэгт дүн шинжилгээ хийж өндөр хөгжилтэй 14 орны 65 өгүүллэгийн дүн мэдээг ашигласан байна. Энэхүү судалгаанд хүний папиллома вирусийн халдвартай холбоотой 14, бэлгийн үүтэй холбоотой 29, хүний папиллома вирустэй холбоотой умайн хүзүүний CIN2 ангиллын дисплази эмгэг өөрчлөлттэй холбоотой 13 судалгааны өгүүллэгийг багтаасан байна. Судалгааны үр дүнд 13-19 насны охидод ХПВ 16, 18 дугаар хэв шинжийн халдварын тархалт вакцин хийснээс хойш 5-8 жилийн дараа 83 хувь, 20-24 насны эмэгтэйчүүдэд 66 хувь, ХПВ 31, 33, 45 дугаар хэв шинжийн халдварын тархалт 13-19 насанд 54 хувиар тус тус буурсан байна. Мөн бэлгийн үү 15-19 насны хөвгүүдэд 48 хувь, 20-24 насны залууст 32 хувиар тус тус буурсан үр дүнтэй байна.

Монгол Улсад хүний папиллома вирусийн халдварын тархалт өндөр байна. Академич П.Нямдаваа нарын 2017 онд хийсэн “Микроаррей аргаар хүний папиллома вирусийн халдварын бүтэц, тархалтыг тодорхойлох судалгаан”-д 302 эмэгтэйг хамруулсан. Уг судалгааны үр дүнгээр хүний папиллома вирусийн халдварын тархалт 45 хувь, үүнээс хавдар үүсгэх чадвар ихтэй 16 дугаар хэв шинжийн вирусийн халдварын тархалт 21 хувь, 18 дугаар хэв шинжийнх 6.3 хувьтай тодорхойлогджээ.

Хүний папиллома вирус нь умайн хүзүүний болон бусад бэлэг эрхтний хорт хавдрын шалтгаан болдог. Хүний папиллома вирусийн тархалт болон олон тооны судалгааны үр дүнг үндэслэн 1991 онд Олон улсын хавдар судлалын агентлаг (IARC) ба Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний папиллома вирусийн халдварыг умайн хүзүүний хорт хавдрын гол шалтгаант хүчин зүйл болохыг анх зарласан.

Энэ утгаараа хүний папиллома вирус (ХПВ)-ийн эсрэг вакцин нь хорт хавдрын эсрэг урьдчилан сэргийлэх зорилгоор хийж байгаа хоёр дахь вакцин болж байгаагаараа онцгой ач холбогдолтой байна.

Судлаач Анагаах ухааны доктор Б.Цэцэгсайхан нарын 2017-2018 онд хийсэн “Хүний папиллома вирусийн эсрэг вакцин хийлгэсэн, хийлгээгүй бүлэгт вирусийн тархалт тогтоох” судалгаагаар нийт 1518 эмэгтэйг шинжилгээнд хамруулсан бөгөөд Хүний папиллома вирусийн эсрэг вакцин хийлгээгүй бүлэгт ХПВ-16 дугаар хэв шинж 79 тохиолдол буюу 10 хувь илэрч байсан бол вакцин хийлгэсэн бүлэгт 7 тохиолдол буюу 0.9 хувь ( $p=0.001$ ) илэрсэн байна.



Хүний папиллома вирусийн эсрэг вакцины нэг бүрийн үнэ 19 мянган төгрөг байдаг бол умайн хүзүүний хорт хавдар (умайн хүзүүний өмөн)-ын зөвхөн мэс заслын эмчилгээний зардалд 3 сая төгрөг, зайн болон дотуур туяа эмчилгээнд 9 сая төгрөг, хими эмчилгээнд (4-6 удаа) 7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг эмчлүүлэгчид нийт 16-20 сая төгрөг зарцуулдаг байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн үндэслэл болон практик шаардлагыг үндэслэн Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц**

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн үр дүнд үндэслэн хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлагыг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Дархлаажуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт нэмэлт оруулах төсөл хэлбэрээр боловсруулна.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр заавал хийх дархлаажуулалтад "А вируст гепатит, пневмококкийн халдвар, хүний папиллома вирусийн эсрэг сэргийлэх тарилгыг нэмж оруулах зохицуулалт хийнэ.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нийгэм, эдийн засагт дараах эерэг үр дүн гарна.

1. А вируст гепатитын халдварын эсрэг вакцинаар дархлаажуулснаар уг өвчнөөр өвчлөх, эмнэлэгт хэвтэх бага насны хүүхдийн тоо эрс буурсан байна. А вируст гепатитын халдварын эсрэг вакциныг тархвар судлалын заалтаар хийж эхэлсэн 2011 оноос өмнө жилд өвчний 9000 тохиолдол бүртгэгдэж байсан бол вакцин хийж эхэлснээс 10 жилийн дараа буюу 2021 онд 18 тохиолдол бүртгэгдэж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх хүүхдийн тоо эрс буурсан байна.

2. Пневмококкийн эсрэг вакциныг хийснээр уг өвчнөөр өвчлөх, нас барах бага насны хүүхдийн тоо буурч гэр бүл, эмнэлэг, улс орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Пневмококкийн халдварын тохиолдол буурснаар антибиотикийн хэрэглээ багасаж, антибиотик эмийн тэсвэржилт үүсэх эрсдэлийг бууруулах, сэргийлэх ач холбогдолтой. Пневмококкийн эсрэг вакциныг нэвтрүүлсний дараа хийсэн судалгаагаар пневмококкоор үүсгэгдсэн уушгины хатгалгаа 26 хувь, хүнд хэлбэрийн хатгалгаа 42 хувь, маш хүнд хэлбэрийн уушгины хатгалгаа 46 хувиар тус тус буурсан.

А вируст гепатит, пневмококкийн эсрэг вакцины зардлыг улсын төсөвт тусган Эрүүл мэндийн сайдын тушаалаар улсын хэмжээнд тархвар судлалын заалтаар дархлаажуулалт зохион байгуулж хэвшсэн тул Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулснаар төсөвт ачаалал үүсэхгүй гэж үзэж байна.

3. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакциныг нэвтрүүлснээр папиллома вирусийн халдварын улмаас үүсэх умайн хүзүүний хорт хавдрын урьдал



эмгэг, умайн хүзүүний хорт хавдар болон бэлэг эрхтэний хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулна.

Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллод 2023 оноос эхлэн нэвтрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд батлагдсан вакцинжуулалтын арга хэмжээний төсөвт багтаан хэрэгжүүлнэ.

Судалгааны дүнгээр хүний папиллома вирусийн эсрэг вакциныг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллод оруулснаар хөдөлмөрийн чадвар алдагдалтаар тооцсон амьдралын жилүүдэд 265 ам.долларын хэмнэлттэй буюу зардал багатай, нийгэмд болон гэр бүлээс гарах зардлыг хэмнэсэн өндөр үр дүнтэй байна.

Хуулийн төсөлд нэмэлтээр тусгагдсан дархлаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тогтолцоо, бүтэц, нэгжийг шинээр зохион байгуулах шаардлагагүй болно.

**Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хүчингүй болгох хуулийн талаар**

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ болон бусад хуультай нийцсэн болно.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт орж байгаатай холбогдуулан ямар нэг хуульд нэмэлт өөрчлөлт орохгүй.

Харин Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товллыг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлуулна.